

ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Р.Баярмаа Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



УЛААНХУС СУМЫН ХӨХ ХӨТӨЛ
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.АЙНУР ТАНАА

2024.02.20 № 143
танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Хөххөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

Аудитын гол асуудал

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402191

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,278,345.56	127,568,299.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,526,992.72	83,290,100.49
31211	Төрийн сангийн харилцах	4,526,992.72	83,290,100.49
33	АВЛАГА	-	710,476.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	710,476.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,751,352.84	43,567,722.84
35410	Бичиг хэргийн материал	3,964,400.00	1,716,500.00
35420	Аж ахуйн материал	17,922,540.00	20,047,540.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	8,352,002.84	657,722.84
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	27,918,350.00	10,551,900.00
35470	Бусад хангамжийн материал	10,594,060.00	10,594,060.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	680,907,481.36	698,549,941.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	680,907,481.36	698,549,941.47
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	675,903,481.36	692,146,423.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	701,769,176.50	707,769,176.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,253,872.48)	(59,963,283.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,835,636.00	39,611,216.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,252,086.15)	(23,081,086.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,324,000.00	43,370,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,125,911.20)	(25,077,333.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,776,787.00	16,776,787.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,798,048.31)	(15,886,853.31)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	8,627,800.00	8,627,800.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	5,004,000.00	6,403,518.35
39301	Програм хангамж	825,000.00	2,248,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(825,000.00)	(848,720.65)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,004,000.00	5,004,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>754,185,826.92</u>	<u>826,118,240.80</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,312,176.00</u>	<u>6,576,008.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>4,312,176.00</u>	<u>6,576,008.00</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,443,308.00	1,443,308.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,637,218.00	5,132,700.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	231,650.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>749,873,650.92</u>	<u>819,542,232.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>749,873,650.92</u>	<u>819,542,232.80</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<u>13,856,951.00</u>	<u>13,856,951.00</u>
51101	Өмч: - төрийн	13,856,951.00	13,856,951.00
51102	- хувийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	<u>735,832,658.92</u>	<u>805,501,240.80</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	735,832,658.92	735,832,658.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	69,668,581.88
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,041.00	184,041.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>754,185,826.92</u>	<u>826,118,240.80</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	386,737,300.00	576,303,869.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	39,244,769.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	27,634,819.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	11,609,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,737,300.00	537,059,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,409,100.00	520,118,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,409,100.00	520,118,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	900,000.00	-

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,428,200.00	16,940,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,428,200.00	16,940,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	384,960,223.83	506,635,287.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,960,223.83	506,635,287.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,910,136.83	506,623,237.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,341,602.28	341,730,452.23
210101	Үндсэн цалин	212,809,544.05	235,092,891.03
210102	Нэмэгдэл	47,769,812.02	90,455,053.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	8,762,246.21	16,182,508.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,104,800.00	46,186,000.00
210201	Тэтгэврийн даатгал	21,563,700.00	28,716,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,635,300.00	6,385,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,108,600.00	2,955,720.00
210204	Ажилгүйдлийн даатгал	526,500.00	739,080.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,270,700.00	7,389,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,822,988.00	25,964,426.00
210301	Гэрэл, цахилгаан	1,331,518.00	2,257,809.00
210302	Түлш, халаалт	7,491,470.00	23,706,617.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,105,190.00	17,695,850.00
210401	Бичиг хэрэг	1,032,800.00	441,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,179,990.00	738,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	16,515,950.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	892,400.00	-
2105	Нормативт зардал	38,740,980.00	51,140,300.00
210502	Хоол, хүнс	38,740,980.00	51,140,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	730,432.00	614,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	730,432.00	614,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,064,144.55	23,292,208.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,779,455.00	4,666,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	920,500.00	1,023,300.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,364,189.55	17,602,358.89
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,087.00	12,050.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,087.00	12,050.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,777,076.17	69,668,581.88
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	402,571.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	402,571.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(402,571.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,374,505.17	69,668,581.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	386,737,300.00	537,059,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,737,300.00	537,059,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	343,409,100.00	520,118,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,409,100.00	520,118,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	900,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	900,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,428,200.00	16,940,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,428,200.00	16,940,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	379,838,537.28	450,685,992.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	379,838,537.28	450,685,992.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,788,450.28	450,673,942.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	267,500,103.28	342,440,928.23
210101	Үндсэн цалин	210,968,045.05	236,694,310.03
210102	Нэмэгдэл	47,769,812.02	89,564,110.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	8,762,246.21	16,182,508.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,733,030.00	46,186,000.00
210201	Тэтгэврийн даатгал	21,563,700.00	31,406,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	263,530.00	3,694,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,108,600.00	2,955,720.00
210204	Ажилгүйдлийн даатгал	526,500.00	739,080.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,270,700.00	7,389,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,272,800.00	16,640,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,331,518.00	2,940,300.00
210302	Түлш, халаалт	11,941,282.00	12,700,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	
2105	Нормативт зардал	53,578,000.00	33,619,850.00
210502	Хоол, хүнс	53,578,000.00	33,619,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,046,500.00	287,950.00
210604	Урсгал засвар	1,046,500.00	287,950.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	798,989.00	614,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	798,989.00	614,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,755,528.00	10,884,914.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,255,685.00	9,079,314.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,499,843.00	1,805,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,087.00	12,050.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,087.00	12,050.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,898,762.72	86,373,107.77
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	7,610,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,610,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		7,610,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(7,610,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,898,762.72	78,763,107.77
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,526,992.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,526,992.72	83,290,100.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	735,832,658.92		749,873,650.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	735,832,658.92	0.00	749,873,650.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	735,832,658.92	0.00	749,873,650.92
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	735,832,658.92	0.00	749,873,650.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	735,832,658.92	0.00	749,873,650.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			69,668,581.88		69,668,581.88

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,856,951.00	184,041.00	805,501,240.80	0.00	819,542,232.80
-----	---------------------------------------	---------------	------------	----------------	------	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,526,992.72
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	541,586,100.00	458,283,942.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,586,100.00	458,283,942.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,586,100.00	458,283,942.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,826,000.00	342,440,928.23
210101	Үндсэн цалин	264,665,300.00	236,694,310.03
210102	Нэмэгдэл	134,699,300.00	89,564,110.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	17,461,400.00	16,182,508.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,154,000.00	46,186,000.00
210201	Тэтгэврийн даатгал	34,784,800.00	31,406,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,092,200.00	3,694,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,273,600.00	2,955,720.00
210204	Ажилгүйдлийн даатгал	818,600.00	739,080.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,184,800.00	7,389,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,640,300.00	16,640,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,940,300.00	2,940,300.00
210302	Түлш, халаалт	12,700,000.00	12,700,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	35,805,200.00	33,619,850.00
210502	Хоол, хүнс	35,805,200.00	33,619,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	287,950.00
210604	Урсгал засвар	300,000.00	287,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	614,500.00	614,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	614,500.00	614,000.00

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,246,100.00	18,494,914.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,402,700.00	16,689,314.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,843,400.00	1,805,600.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	537,059,100.00	537,047,050.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	520,118,800.00	520,118,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	520,118,800.00	520,118,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,940,300.00	16,928,250.00
132001	Орон нутгийн төсвөөс	16,940,300.00	16,928,250.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,526,992.72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		83,290,100.49
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26.00	26.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь “Бага насны хүүхдийг эрүүл орчинд хүн болох багаасаа ардын сурган хүмүүжүүлэх ухаанд тулгуурлан, зөв сэтгэлгээтэй, нийгэмд зохицон амьдрах чадвартай Зөв монгол хүнийг хөгжүүлж төлөвшүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газар, аймгийн ЗДТГ болон Санхүүгийн хяналт, отоод аудитын албанаас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71.9 сая төгрөгөөр буюу 109.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгө	4526.9	83290.1	78763.2
Авлага	0	710.5	710.5
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	68751.4	43567.7	-25183.7
Үндсэн хөрөнгө	680907.5	698549.9	17642.4
Нийт хөрөнгө	754185.8	826118.2	71932.4
Өр төлбөр	4312.2	6576.0	2263.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	749873.6	819542.2	69668.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	754185.8	826118.2	71932.4

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 83.3 сая төгрөг болж оны эхнээс 78.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 79.4 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 1.7 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардал, 2.2 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Оны эцэст 0.7 сая төгрөгийн авлагатай гарсан нь нийгмийн даатгалын шимтгэлд төсвөөс илүү шилжүүлж авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 43.6 сая төгрөг болж 25.2 сая төгрөгөөр буурсан байна. Хүнсний материал 10.5 сая, аж ахуйн материал 20.0 сая, бичиг хэргийн материал 1.7 сая, түлш, шатах тослох материал 0.6 сая, бусад хангамжийн материал 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өмнөх жилүүдэд хоолны зардлын төсвөөс худалдан авсан хүнсний материал дансанд бүртгэж ирсэн 18.6 сая төгрөгийн залруулга хийсэн байна. Үүнд: бичиг хэргийн материалд 2.7 сая, аж ахуйн материалд 6.1 сая, түлш, шатах тослох материалд 0.9 сая төгрөгийн материал шилжүүлэн, тооллогоор илэрсэн хүнсний материал 1.8 сая бүгд 11.6 сая төгрөгийн материалыг бараа материал дансанд, үндсэн хөрөнгөд 6.9 сая төгрөгийн хөрөнгө, материалыг шилжүүлж бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17.6 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө 27.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 17.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 71.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 69.7 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 402.6 сая, орон нутгийн төсвөөс 16.9 сая, нийт зарлагыг 419.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 378.8 сая төгрөгөөр хянаж, 23.8 сая төгрөгөөр бууруулж баталсан ба төсвийн тодотголоор 141.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 520.1 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 16.9 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 520.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 16.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 537.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 520.1 сая, орон нутгийн төсвөөс 16.9 сая нийтдээ 537.0 сая төгрөгийн санхүүжилт авч 4.5 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 458.3 сая төгрөг буюу 84.6 хувьтай, дансанд 83.3 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	921.7	921.7	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	34419.2	33199.8	1219.3	96.4%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2117.0	2117.0	0	100%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	2021.7	926.0	1095.7	45.8%
5	81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	4446.0	691.7	3754.3	15.5
6	81834	Боловсролын стандарт, сургалтын	248705.5	202656.9	46048.6	81.5%
7	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	223434.7	192262.5	31172.2	86%
8	81605	Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	8580.0	8580.0	0	100%
9	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	16940.3	16940.3	0	100%
Нийт дүн			541586.1	458295.9	83290.1	84.6%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 83.3 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 74.4 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 5.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 1.7 сая, хүүхдийн хоолны зардал 2.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 56.4 сая төгрөгийн бараа материал, 7.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймгийн төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 44 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 384.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулах зөвлөмж, нярвын хүнсний материалын тооцоог сар бүр хийж, үлдэгдлийг баталгаажуулах 27.9 сая, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 0.8 сая төгрөгийн албан шаардлага, нормативыг хэтрүүлж зарцуулсан 5.1 сая, анхан шатны нотлох баримтгүйгээр илүү зарлага гаргасан 2.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичигдсэн байна. Давтан шалгаж үзэхэд төлбөрийн актаас 0.3 сая төгрөг барагдуулж, зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	80,19.7		300.0	3.7%
Албан шаардлага	2	28,718.3	2	28,718.3	100%
Зөвлөмж	1	0	1	0	100%
Нийт дүн	5	36,738.0	3	29018.3	67.9%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай. Дараагийн аудитаар нярвын бараа материалын тооллого, тооцоог анхаарах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 15.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрч 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 14.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 1.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоогдсон. Үүнд:

Ажиллагсдын цалингаас нийтдээ 25,225.7 мянган төгрөгийн цалингийн ашгийн татварыг суутган авч 23,618.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 1607.3 мянган төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Жилийн эцсийн тооллого, тооцоотой холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/43 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг томилж, тооллого хийсэн боловч хүнсний материалын тооллогын бүртгэлийг үнэн зөв хөтөлж баримтжуулаагүй, нярвын агуулахын бүртгэл хөтлөлт, бараа материалын тайлан гаргалт, баримтжуулалт хангалтгүй хийгдсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын жилийн эцсийн тооллогын бүртгэлийг дахин хөтөлж, баримтжуулах нярвын агуулахын бүртгэл, бараа материалын тайланг зохих журмаар хөтөлж баримтжуулалтыг сайжруулах.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 14.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
					Хариуцлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	

Улаанхус сумын Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	14,040.0					1	14,040.0				
татварыг төсөвт төвлөрүүлээгүй	1	1,607.3	1	1,607.3								
Бараа материалын тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй	1	0					1	0				
Дүн	3	15,647.3	1	1,607.3			2	14,040.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								